



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 349

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн 2015 оны 09 дугаар сарын 29-ний өдрийн 15/07/025/42 дугаар актаар ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, засаж сэлбэн ашиглах боломжгүй нийт 33,590,335.00 (гучин гурван сая таван зуун ерэн мянга гурван зуун гучин тав) төгрөгийн балансын үнэ, 15,144,659.04 (арван таван сая нэг зуун дөчин дөрвөн мянга зургаан зуун тавин есөн төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Барилга байгууламжийг буулгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон орлогод авах хоёрдогч түүхий эд болгон ашиглах, хог хаягдлыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх, чөлөөлсөн газрыг төрийн байгууллагын мэдэлд хэвээр үлдээж зориулалтаар нь ашиглах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001586
16-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн
339 дугаар тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨНД БҮРТГЭЛТЭЙ АКТАЛЖ, ДАНС-НААС ХАСАХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Хаяг, байршил	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэх өртөг (төгрөгөөр)
Нисэх буудлын хуучин барилга						
1	Буудлын барилга тоосго	Өвөрхангай аймгийн Хужирт сумын 5-р баг	2000/08/01	31,063,135.00	12,670,253.28	18,392,881.72
2	Аэродроммын хашаа	Өвөрхангай аймгийн Хужирт сумын 5-р баг	1988/12/01	2,527,200.00	2,474,405.76	52,794.24
Нийт дүн						
				33,590,335.00 (гучин гурван сая таван зуун ерэн мянга гурван зуун гучин таван)	15,144,659.04 (арван таван сая нэг зуун дөчин дөрвөн мянга зургаан зуун тавин есөн төгрөг дөрвөн мөнгө)	18,445,675.96 (арван найман сая дөрвөн зуун дөчин таван мянга зургаан зуун далан таван төгрөг ерэн зургаан төгрөг)